МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.06.11 № ЗЗГ/2037

танай _____-ны №_____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
У.ОТГОНБАЯР ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Та бүхнээс санаачлан боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 02 хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР

000265006992

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
Т Э М Д Э Г Л Э Л Э Э С

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"6.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын нэр бүхий гишүүдээс санаачлан боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын нэр бүхий гишүүдээс санаачлан боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах үндэслэлээр төслийг бүхэлд нь дэмжих боломжгүй саналыг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов:

1.Хуулийн төсөлд хаврын хурдан морины уралдааныг "хаврын тэргүүн сарын шинийн 15-ны өдөр, эсхүл түүний доторх аль нэг өдөр" Засгийн газрын шийдвэрээр жил бүр аймаг, нийслэлд зохион байгуулах, уралдааны морийг 14 ба түүнээс дээш насны хүүхдээр унуулах, уг уралдааныг зохион байгуулах бэлтгэл, аюулгүй байдлыг хянах журмыг Засгийн газар батлахаар тусгасан байна.

Гэвч дээрх зохицуулалт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх, хөдөлмөр эрхлэлтийн талаарх хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомж болон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэртэй нийцэхгүй байна. Тодруулбал:

1.1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 1 дүгээр зүйлд "...18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд..." гэж, мөн конвенцын 6 дугаар зүйлд "Оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана" гэж, Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ." гэж, Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт "...хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж тус тус заасан.

Иймд 14 ба түүнээс дээш насны хүүхэд буюу 18 нас хүрээгүй хүүхдийг хаврын хурдан морины уралдаанд оролцуулахыг зөвшөөрсөн агуулгатай зохицуулалт нь хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах талаар Монгол Улсын хүлээсэн олон улсын үүрэгтэй нийцэхгүй байна;

1.2.Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл түүний эрхийг хамгаалахаар, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад "төр, иргэн, хуулийн этгээд үйл

ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах" зарчмыг баримтлахаар тус тус заасантай нийцэхгүй байна;

1.3.Улсын дээд шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 26 дугаар тогтоолоор Засгийн газарт жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, бэлтгэлийн явцад хүүхдээр морь унуулах болон аливаа хэлбэрийн морин уралдаан зохион байгуулахыг хориглосон захиргааны хэм хэмжээний акт батлахыг даалгасан.

Дээрх шүүхийн шийдвэрийн дагуу Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолоор жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглосон.

Мөн дээрх тогтоолд Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж, жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд 18 хүртэлх насны хүүхдээр хурдан морь унуулахыг хориглосон бөгөөд хуулийн төсөлд тусгасан "хаврын тэргүүн сарын шинийн 15-ны өдөр, эсхүл түүний доторх аль нэг өдөр" гэсэн зохицуулалт нь хүүхдээр хурдан морь унуулахыг тодорхой хугацаагаар хориглосон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дээрх зохицуулалттай нийцэхгүй байна." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР